



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/328

Булган сум

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын
тамга, тэмдгийг түших албан тушаалтныг
томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор баталсан "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам"-ын 6.6 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 8.1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын тамга, тэмдгийг түших албан тушаалтнаар Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Доржийн Наранбаярыг томилсугай.

2. Байгууллагын албан хэрэгт хэрэглэж байгаа тамга тэмдгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Д.Эрдэнэбилэг), "Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль", "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам"-ыг мөрдлөг болгон ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 16-ны/ний өдрийн
А/328 дугаар захирамжийн хавсралт



Тамга, тэмдгийг түших албан тушаалтны жагсаалт

д/д	Албан тушаал	Тамга, тэмдэг
1	2	3
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	Аймгийн Засаг даргын Тамгын газрын тамга
2		Аймгийн Засаг даргын Тамгын газрын тэмдэг ГЮА0004